



1. Батноров сумын газар нутгийн танилцуулга



Нийт 496829 га газар нутагтай. Үүнээс: Бэлчээр 475352 га, газар тариалан 947 га, хадлан 13700 га, хот суурин бусад суурин газар 1113 га, ойн сав бүхий газар 1041 га, усан сан бүхий газар 1245 га. Монгол орны тал хээрийн бүсэд оршдог. Хойд цэгээс урд цэг хүртэл 118 км, баруунаас зүүн зүг хүртэл 74 км буюу хойноосоо урагш сунаж тогтсон газар нутагтай. Нийт 5466 хүн амтай. Эрдэнэчандмань, Эхэнбүрд, Баян, Баянбулаг, Идэрмэг, Дундбүрд, Бэрх гэсэн 7 багтай. Хэнтий аймгийн Баян-Овоо, Норовлин, Биндэр, Баян-Адрага, Баянхутаг, Хэрлэн гэсэн 6 сумтай хиллэдэг. . Эрс тэрс уур амьсгалтай зундаа +40 хэм хүртэл халж, өвөлдөө -30-38 хэм хүрч, хавар, намрын улиралд хавсарга салхи салхилна. Улсын чанартай сайжруулсан шороон зам Өндөрхаанаас Батноров, Норовлин, Баян-Уул сумдуудаар дайрч Оросын хил Ульханы боомт хүрнэ.

2. Хүн амын тоо ,яс үндэс,соёл, уламжлал,ёс заншлийн онцлог

Батноров сум нь 2016 оны жилийн эцсийн хүн амын тооллогоор 5262 хүн амтай. . Халх үндэстэн 98% эзэлдэг.Сүүлийн жилүүдэд хүн амын тоо тогтмол өсөж байна. Батноров сум нь 1923 онд байгуулагдсан. , 1973 онд Идэрмэг сум татан буугдаж зарим хэсэг нь Батноров суманд харьяалагдсан. Сумын иргэдийн 70 гаруй хувь нь мал маллаж амьдардаг. Тус суманд адууг унаж эдлэх, эдлэл хэрэгсэлийг соёл түлхүү хөгжсөн. Батноров сумаас Монгол улсын урлагийн гавьяат зүтгэлтэн хөгжмийн зохиолч Б.Цэрэндорж, МУГЖ, жүжигчин Н.Рэнцэнноров, зураач зохиолч доктор Ж.Саруулбуян зэрэг урлаг соёлын алдартнууд төрөн гарсан.



МУГЗ Г.Цэрэндорж



Зохиолч, зураач, доктор Ж.Саруулбуян



БНМАУ-ын гавьяат жүжигчин Ө.Рэнцэнноров

3. Сумын брэнд бүтээгдэхүүн, түүний онцлогийн талаар:

Батноров хийцийн мөнгөн эдлэл хэрэглэл.

Олноо Тожил хэмээн алдаршсан дархан Б.Ишжамц нь монгол дархны урлагт цутгуурын аргыг нэвтэрүүлж монгол даяар алдаршсан “Батноров хийц”-ийн мөнгөн эдлэлийн хийцийг үүсгэн дэлгэрүүлсэн бөгөөд өөрийн гарын 20 иод шавийг сургаснаас тэдний шавь ,шавийн шавь буюу 3,4 дэх үеийн дархчууд өвлөн уламжлуулан хөгжүүлж байна.




Батноров хийцийн хэт хутга.




Батноров хийцийн эмээлийн
мөнгөн хэрэглэл.

4. Малын тоо, ангилал, сүүлийн 5 жилээр:


Тэмээ




Адуу




Үхэр



Хонь



Ямаа



Амьтан ургамлын аймаг, төрөл, зүйл ангилалын талаар:

Нутгийн хойд уулархаг хэсгээр хус, бургас, улиас, яргай, хайлаас гачуур зэрэг жижиг ой төгөлтэй, нохойн хошуу, дэгд, тарваган шийр, цөс өвс, таван салаа, сөд, бамбай, уулын цагаан төмс зэрэг эмийн ургамал, уул, хээрийн хярганат хиаг, үетэй хялганат, шивээт хялгана, түнхлээ, хиаг, саман ерхөг, цэцэгт дааган сүүл гэх мэт бэлчээрийн ургамал зонхилон ургадаг. Тарваган буга, бор гөрөөс, цагаан зээр, саарал чоно, үнэг, хярс, дорго, мануул, шилүүс, туулай, чандаг зэрэг ан амьтад, шонхор, тас, сар, хур, сойр, шаазгай, ятуу, болжмор, хараацай, усны шувуудаас тогоруу, галуу, ангир, хун, нугас зэрэг жигүүртэн шувуудтай. Хэрлэн голд сөөм булуу цагаан, зэвгэ, цурхай зэрэг загастай. Тогоруу, хун, галуу, нугас, ангир зэрэг усны шувууд, шар шувуу, шонхор, тас, сар, хур сойр, ятуу, болжмор, хэрээ, хараацай шувууд нутагладаг.

Гүн далай, Хунт нуур, Цагаан нуур, Олон нуур зэрэг жижиг нуур, Хэрлэн мөрөн, Зос, Жаргалант, Загастай, Бүрд, Ихэт, Харз, Зүрхийн бүрд гэх жижиг голуудаас гадна жижиг булаг шандуудтай.



5. Түүхийн дурсгалт газруудын тухай мэдээлэл:



2017 онд зураач барималч Батхуягийн зураг төслөөр бүтээгдсэн “Батноров хийц” эмээлийн цогцолбор “ хөшөө /Сумын төв Бүрдэн толгой /



2011 онд зураач зохиолч эрдэмтэн Ж.Саруулбуянгын зураг төслөөр баригдсан Боорчийн цэцэрлэгт хүрээлэн



Тэмүүжин 8 шарга агтаа алдан эрж явахдаа Наху баяны хүү Боорчтой танилцан анд бололцсон Хөхүүрийн тал

/Баян булаг багийн нутагт сумын төвөөс 18км/



Нутгийн ард иргэдийн хүсэл биелдэг гэж үзэж тахиж шүтдэг Аав хад

/Сумын төвөөс баруун ургаш 15 км/

Суварган хөндий



БНХАУ-ын Батлан хамгаалахын сайд, Хятадын анхны 13 маршалын нэг Лин Бяогийн хөлөглөсөн онгоц 1970-аад оны эхээр тус сумын нутаг Суварган хөндий гэдэг газарт осолдсон байдаг. Энэхүү газарт сүүлийн жилүүдэд аялал жуулчлалын газар авах хүсэлт ихээр ирж байгаа ба гадаадын жуулчид их ирж үздэг болсон.





Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор жил бүрийн 11 сард зохион байгуулдаг “Талын түмэн адуу” эвент арга хэмжээг Мөнх харилцаа ТББ тай хамтран 5 дахь жилдээ зохион байгуулж байна. Энэхүү эвентэд оролцох гадаад дотоодын жуулчдын тоо жилээс жилд нэмэгдэж цар хүрээ нь өсөн нэмэгдсэн.

6. Байгалийн баялаг ашигт малтмалын орд газрын тухай:

Газрын хөрсөн дор хайлуур жоншны орд элбэг тул 1950-тад оны эхэн үеэс олборлолтууд хийгдэж одоог хүртэл үргэлжилж байна. Үүнд: Бухат, Хавтгай -1,

Хавтгай- 2, 3, Ямаат, Сэртэн, Шувуут, Майл, Улаан-Өндөр, Дэлгэрхаан, Идэрмэг, Баянхаан, Чимэдийн хөндлөн, Цагаан гозгор, Мааль, Цагаан Өндөр, Сэрвэн, Ухаа овоот, Түгээмэл тархацтай шороон будаг, элс, элст хайрга, шар-цагаан шаврын ордууд байдаг. Тус суманд одоогийн байдлаар 11 ашиглалтын лиценз, 25 хайгуулын лиценз байна. Мөн “Ресурс Минком” ХХК-ны жоншны баяжуулах үйлдвэр үйл ажиллагаагаа явуулж байна.



Жижиг дунд үйлдвэрлэл:

Сумын хэмжээнд Оёдол, модон эдлэл, гар урлал, алт мөнгөний дархан, гурил гурилан бүтээгдэхүүн зэрэг нийт 20 гаруй жижиг дунд үйлдвэрлэгч байдгаас тогтомол идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 12 үйлдвэрлэгч байна. Ихэвчлэн оёдол монгол гутал, гар урлалы чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Ахуй үйлчилгээнд үйлдвэрлэл явуулдаг иргэдийн бүтээл:



Гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч сумын хэмжээнд 3 газар байдаг бөгөөд сумын талхны хэрэгцээг бүрэн хангаж байна.



Цаашид хөгжих боломжтой жижиг дунд үйлдвэрлэл:

Өрхийн аргаар үхэр бордож мах боловсруулах чиглэлээр үйл ажиллагаагаа эхлэж байна. Цаашид эрчимжсэн мал аж ахуйн фермерийг хөгжүүлх:

